

まんがでわかる



Монгол хэл  
МОНГОЛ ҮГ

# 交通労働災害の防止

Комикоор мэдэх

Зам тээврийн үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх нь



Энэхүү дуу дүрст сургалтын материал нь ажилчид та бүхэнд зам тээврийн үйлдвэрлэлийн ослоос сэргийлэхэд зориулсан дүрэм болон аюулгүй байдлын үндсэн мэдлэг олгоход зориулан боловсруулсан материал болно.



За тэгэхээр!  
Өнөөдөр зам тээврийн  
үйлдвэрлэлийн ослоос сэргийлэх  
талаар суралцацгаая.



Ажлаар тээврийн  
хэрэгсэл унах тохиолдол  
байдаг болохоор  
мэдүүштэй юм байна шүү.

Тийм шүү...



Би  
ачааны машины жолооч  
болохоор өдөр бүр  
шахуу машин  
жолооддог шүү.

Би борлуулалтын  
ажлаар машин,  
унадаг дугуйг  
ашиглах нь  
олон байдаг даа.



Ийм ойр  
байдаг тээврийн  
хэрэгсэлд осол  
ихээр тохиолддог  
юм шүү.

Хөөх ~!


Тэгэхээр зам тээврийн  
үйлдвэрлэлийн осол нь  
ямар салбарт их  
тохиолддогийг харцгаая.




**Зам тээврийн  
үйлдвэрлэлийн ослын тоо**

1	Худалдааны салбар	1672
2	Харилцаа холбоо	866
3	Газрын ачаа тээврийн салбар	792
4	Зам тээврийн салбар	740
5	Эрүүл мэнд, эрүүл ахуйн салбар	612
6	Барилгын салбар	542

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам "Үйлдвэрлэлийн осол үүссэн байдал (2020 он)"




Мэргэжлийн жолооч ажилладаг  
салбараас гадна гуравдагч салбарт ч  
мөн ялгаагүй зам тээврийн үйлдвэрлэлийн  
осол их байна шүү.



Салбар харгалзахгүй зам тээврийн үйлдвэрлэлийн осол олон байгаа нь явган болон унадаг дугуйгаар ажилдаа ирж очих үед осолд өртөж байгаа гэсэн үг.



Түүнчлэн, "газрын ачаа тээврийн салбар", "зам тээврийн салбар", "барилгын салбар" гэх салбаруудын автомашин ашиглах ажилд ачаа ачих, замын хөдөлгөөн зохицуулж байх зэргийн ажлын талбай дээрх осол ч бас гарч байна.



Зөвхөн жолооч нь осол гаргаад байгаа бус, ачааны машины ойролцоо ажил хийж байгаа хүн нь ачааны машинд дайруулах тохиолдол ч олон байдаг.

Гэмтэл авч ажил хийх боломжгүй болбол ар гэрийнхэн нь ч санаа зовж, өрхийн орлого ч бас хүнд болно...



Тийм учраас тогтмол бэлтгэлтэй байх нь чухал.

Ялангуяа том оврын машинуудын сохор бүсний талбай том байдаг тул ойр орчимд нь хүн байсан ч анзаарч харахад хүндрэлтэй байдаг. Эргэн тойронд ажил хийж байгаа хүн ч том оврын машины сохор бүсийг мэдэж авах нь чухал шүү.

Мөн, яарч байсан ч тайвнаар аюулгүй байдлыг шалгасны дараа үйл хөдлөл хийх нь ч чухал юм.



Тухайлбал ямар тохиолдлууд байсан бэ?

Зогсож байгаа ачааны машины ардуур эгц хөндлөн гарч байхад ачааны машин гэнэт арагшаа хөдөлж дайруулсан тохиолдол байдаг.

Жолоочийн суудлаас ажилчин харагдахгүй болохоор осол болсон байх нь.



Аймаар юм....

Тийм үйлдвэрлэлийн осол гаргахгүйн тулд,

юуны өмнө ослоос сэргийлэхийн тулд үндсэн мэдлэгийн тухай үзэж танилцацгаая!

За!





**Ажилдаа  
ирж очих  
үеийн анхаарах  
зүйлс  
(Унадаг дугуй)**



Унадаг дугуйгаар ажилдаа ирж очих үеийн замын хөдөлгөөний дүрмийг ч бас цээжилж авцгаая.

Японд унадаг дугуй нь тээврийн хэрэгслийн нэг төрөл юм.

Тиймээс тээврийн хэрэгсэлтэй ижил замын зорчих хэсгийн зүүн гар талаар явах шаардлагатай.

Зарчмын хувьд замын зорчих хэсэг ба явган хүний зам хамаарахгүй.



Онцгой тохиолдолд унадаг дугуй зорчих боломжтой явган хүний зам байдаг.



Хөөх, энэ тэмдэг байгаа явган хүний замаар унадаг дугуйтай явж болох нээ.

Тэр тохиолдолд анхаарууштай зүйл бол явган зорчигчдыг давуу эрхтэй!



Замын зорчих хэсгийн хажуугаар удаан явах хэрэгтэй юм байна тэ.


**Унадаг дугуй унах үеийн аюулгүй байдлын дүрэм**




Сундалж явахыг хориглоно.



Шүхэр барьж унахыг хориглоно.



Зэрэгцэж явахыг хориглоно.



Шөнийн цагаар гэрлээ асаах үүрэгтэй.




Согтуугаар унадаг дугуй унахыг хориглоно.



Уулзвар дээр түр зогсох, аюулгүй байдлыг шалгах



Явж байхдаа гар утас ашиглаж болохгүй



Явган хүний гарцаар гарахдаа бууж, түрж алхах (явган зорчигчийн хөдөлгөөнд саад болохгүй байхаас бусад үед)

\* Унадаг дугуй бол тээврийн хэрэгслийн нэг төрөл бөгөөд үүнээс гадна ч бас төрөл бүрийн дүрэм журам байдаг.

# Унадаг дугуйг аюулгүй унах арга




## Уруудахдаа хэт хурдлахгүй байхад анхаар.



Япон нь өгсүүр уруу зам олон байдаг тул анхааралтай байхгүй бол!

## Бороотой үед траншейний таг дээр хальтирахаас болгоомжил.



Бороотой үед траншейний таг хальтирахад хялбар байх нээ.



## Унадаг дугуйг тогтмол шалгаж байх

**Урд болон** хойд дугуйны тоормос сайн ажиллаж байгаа эсэх.

**Урд гэрэл (гэрэл)** тод асаж байгаа эсэх.

**Дугуйны** хий хангалттай сайн байгаа эсэх, хээ нь элэгдэж мөлийсөн эсэх.

**Руль нь урд** дугуйтай эгц бөгөөд сул хөдөлгөөн байхгүй эсэх

Тэгэхээр, унадаг дугуйгаа тогтмол шалгаж байвал сэтгэл амар юм байна.

**Суудал нь** холхиж суларсан эсэх, хоёр хөлийн өлмий газарт зэрэг хүрэх өндөрт байгаа эсэх.

**Цацруулагч** байгаа эсэх, бохирдсон эсэх, сайн харагдаж байгаа эсэх.

**Гинж** нь хэт сул байгаа эсэх.

**Дөрөө** нь гулзайж хөл хальтирч байгаа эсэх.

**Бусад эд анги нь** сайтар бэхлэгдсэн эсэх.

Унадаг дугуйн хувьд өөр юуг анхаарах вэ?

Өө тийм...

Сүүлийн үед унадаг дугуйн хүргэлт хийж байхад гарах осол нэмэгдэж байгаа.

Хмм...

Хурдан хүргэж өгөхгүй бол болохгүй гэж бодоод улайрчихдаг байхаа.

Улайрах бол ослын үндэс шүү.

Завгүй байсан ч аюулгүй байдлаа шалгахаа ягштал хийх нь чухал юм шүү.

**Ажилдаа ирж очих үеийн анхаарах зүйлс (автомашин, мотоцикл)**

Машин эсвэл мотоциклоор ажилдаа ирж очих талаар үзэцгээе.



Юуны өмнө жолооны үнэмлэхний талаар тайлбарлая.

Японд машин жолоодохын тулд дараах үнэмлэхний аль нэгийг авсан байх шаардлагатай.

Японд жолоо барих боломжтой жолооны үнэмлэх

**Япон жолооны үнэмлэх**



\* Гадаад улсад авсан жолооны үнэмлэхийг Япон улсын жолооны үнэмлэх рүү шилжүүлсэн тохиолдлууд хамаарна.

**Женевийн конвенцид үндэслэсэн олон улсын жолооны үнэмлэх**

**Гадаад улсын жолооны үнэмлэх (Япон хэл дээрх орчуулгыг хавсаргасан зүйл)**

\* Одоогоор Швейцарийн холбооны улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Бельгийн Вант Улс, Монакогийн Вант Улс, Тайвань улсуудаар хязгаарлагдаж байна.

**Японд жолоо барих хугацаа**

Хүчинтэй хугацааны туршид.

**Японд жолоо барих хугацаа**

Японд ирсэн өдрөөс хойш нэг жил эсвэл жолооны үнэмлэхийн хүчинтэй хугацааны аль нь богино хугацаа.

**Японы замын хөдөлгөөний дүрэм**


Замын хөдөлгөөний дүрмийг ч бас сайтар мэдэж авцгаая.




**Явган хүний гарц дээр явган зорчигч давуу эрхтэй.**



**Улаан гэрлээр явахыг хориглоно.**



**Зүүн гар талаар зорчих.**



**Гар утас зэргийг ашиглах хориотой.**



Ухаалаг утас болон замын хөтөчид анхаарал хандуулснаас болж осол гаргах тохиолдол олон байдаг.

60 км/ц хурдтай явж байхад 2 секундэд 33.3м зам туулна.

2 секундын хугацаанд явган зорчигч зам хөндлөн гарч байвал осол болох нээ.

“Анхаарал сарнисан жолоодлого” аюултай юм аа.

**Ослоос сэргийлэхэд зорилготой дүрэм**

Угталцан мөргөлдөх ослоос сэргийлэхэд зориулсан дүрмийг ч бас цээжилцгээе.



Түр зогсох тэмдэг байгаа газар заавал зогс.

Японы түр зогсох тэмдэг нь олон улсын стандартаас өөр байдаг тул анхаарах шаардлагатай юм байна.

Олон улсын стандарт



Япон



**Ослоос сэргийлэхийн тулд мэдэж авууштай мэдлэг**


"Байж магадгүй жолоодлого"-д хэвшицгээе.

Юмыг яаж мэдэхэв "... байж магадгүй" гэх үргэлж ослоос сэргийлэх үүднээс аюулыг урьдчилан тооцоолох жолоодлого хийх нь чухал шүү.

Машины цаанаас хүн гарч ирж магадгүй.



Урд явж байсан машин гэнэт тоормослож магадгүй.



Баруун гар тийш эргэхэд өөдөөс ирж байгаа машин зогссон ч хажуугаар нь мотоцикл гараад ирж магадгүй.





# Автомашин, мотоциклын аюулгүй жолоодлогын арга

Осол гаргахгүй  
байхын тулд

өөр  
анхаарах зүйлийг ч  
үзэж танилцъя.



# Ажлын талбай дээр урьдчилан сэргийлэх зүйлс

Ажлын талбай дээр  
эргэн тойронд байгаа  
ачааны машинуудаас  
болгоомжлох нь маш чухал юм.

Ачааны машин зэрэг том оврын  
тээврийн хэрэгсэлд сохор бүс олон байдаг.  
Замын хөдөлгөөн зохицуулах болон  
үйлдвэрийн талбай зэрэгт сохор  
бүс рүү орохоос болгоомжил.

## Ачааны машины сохор бүс

Жолоочийн арын  
зүүн баруун ташуу  
бүс нь сохор бүс  
болоход хялбар  
байдаг.

Тээврийн хэрэгслийн  
арын хэсэг нь гарцаагүй  
сохор бүс болно.




Өндөр автомашинуудын хувьд сохор бүс  
яг жолоочийн урд байдаг.

## Ачааны машины хойт дугуйн мөрний зөрүү

Машин эргэх үед урд дугуйны явсан  
мөрнөөс арын дугуй дотор талаар нь  
явахыг "Хойт дугуйн мөрний  
зөрүү" гэж хэлнэ.

Ялангуяа том оврын  
тээврийн хэрэгсэлд  
хойт дугуйн мөрний  
зөрүү их болдог.

Хангалттай хол байгаа гэж  
бодсон ч хавчуулагдах  
тохиолдол байдаг  
тул болгоомжтой байгаарай.



Хол байсан ч  
хавчуулагдана!

Зөвхөн урд төдийгүй хойд, зүүн, баруун  
талын аюулгүй байдлыг шалгаарай!



Жолоо барьж байхдаа харилцаа  
холбоог ч бас бүү алдаарай!



Цаг агаарын таагүй үед  
машин жолоодохдоо  
хальтиргаа гулгаанаас болгоомжил!



Бороо, цас, хөлдөлт,  
манан, хүчтэй салхи гэх  
мэтээс болгоомжил.

Орон сууцны хороолол, нарийн замд  
явган зорчигч, унадаг дугуй зэргийг  
анхаарч, удаан яваарай!



Аюулгүй жолоодлого хийж  
хэн нэгнийг хохироохгүй бол тэ

Гэм буруутан болбол...

Аааа...  
яасан ч биш...

### Эрүүгийн хариуцлага



Хохирлын нөхөн төлбөр болон  
торгууль, хорих шийтгэл зэрэг эрүүгийн  
хариуцлага хүлээж болзошгүй.

### Сахилгын шийтгэл болон ажлаас халагдах



Компанийн дүрэм журмаас хамааран  
танд сахилгын шийтгэл ногдуулах эсвэл  
ажлаас халах ч тохиолдол байдаг.

### Нийгмийн байр суурь алдагдах



Телевизээр жинхэнэ нэр  
зарлагдах тохиолдол ч байдаг.  
Ялангуяа согтуугаар тээврийн хэрэгсэл  
жолоодох нь нийгмийн анхааралд  
өртөх нь өндөр байдаг.


**Ачааны машины эргэн тойронд ажиллах санаанууд**



Замын хөдөлгөөн зохицуулах харуул болон ачааны машины жолоочийн туслах зэргийн ажил нь сохор бүс үүсгэхэд хялбар бөгөөд гэнэт гарч ирэх, анхаарал болгоомжгүйгээс үүдэлтэй осол гаргахдаа хялбар байдаг.

Ачааны машины эргэн тойронд ажиллахдаа юуг анхаарах хэрэгтэйг харцгаая!


**Ачааны машинд ачаа ачих үеийн сохор бүсээс болгоомжил.**



**Агуулах болон барилгын талбайд сохор бүс болон явж буй тээврийн хэрэгслээс болгоомжилно.**



**Жолооч сохор бүсэд орохгүй байх.**



Явган сууж ажиллах нь жолоочид харагдахдаа муу байдаг тул ажилчид ч бас анхаарах хэрэгтэй. Мөн, нүдэнд тод харагдахуйц ажлын хувцас өмсөнө.


**Зохицуулалт хийх үеийн анхаарал сарнихаас болгоомжил.**




**Зам дээр гэнэт гарч ирэхгүй.**



**Тээврийн хэрэгслийн дэргэдүүр өнгөрөхдөө аюулгүй байдлыг шалгана.**



**Агуулах болон талбай доторх дүрмийг баримтална.**






Ойлгосон уу?

За тэгэхээр дараагаар нь жинхэнээсээ ямар тохиолдлууд байсан талаар сөхөж үзэцгээе.




# CASE 1





Барилгын талбай хүртэл жаахан л зай байна! Гялалзанаа!






**Нөөц цаг хугацаатай байх!**



Улайрах нь аюултай жолоодлоготой холбогддог тул тайван алгуур үйлдэл хийгээрэй.

**Унадаг дугуй бол зүүн гарын дүрмээр явна!**



Явж байгаа газартаа дүрмээ баримталснаар ослоос урьдчилан сэргийлэх боломжтой.

**Унадаг дугуй нь зарчмын хувьд явган хүний замаар явах ёсгүй!**



Явган хүний замаар явахдаа явган зорчигчдод давуу эрх олгож явна.

**Шүхэр барьж дугуй унаж болохгүй!**



Шүхэрээр үзэгдэх орчин хумигдах, тэнцвэр алдах зэргээр маш аюултай.

**Дуулга өмсөцгөөе!**



Унадаг дугуйн ослоор нас барж байгаа хүмүүсийн 56% нь толгойдоо гэмтэл авсан байдаг. (2020 онд)



# CASE 2



Яаа, өнөөдөр ч ядарлаа шүү...

Өө, цас!?

Унадаг дугуйгаар харьж болох байгаа.

Юутай ч алхмааргүй байна...



Хүн байхгүй байхад, зүгээр биздээ.

Өөө нөхөөр!?



Зам нь зүгээр л нойтон, хөлдөөгүй юм шиг байна

Яаж ийгээд явж болох байлгүй!



Түр зогсох тэмдэг байна...



Уучлаарай...



Осолтой байлаа...

Юу?




Цас орсон болохоор амархан хальтирдаг болсон байна уу.



Цастай өдөр бол осолтой юм аа.



Ачааны машин. Орой ажиллаад хэцүү шүү...



Ааа!

Өөш.

Уучлаарай



Зсс.

Машин санаснаас ойрхон ...!?



Ядарсан үед алдаа их гарах юм аа...



Энд олон машин ихтэй болохоор зам хөндлөн гарахад их хэцүү байгаа.

Явган хүний гарц ч бас хол.



Хөөш !!  
Замаа хараачээ !!



Нэг хормын ч болтугай өмнө гэртээ харихсан.



Машин ирж байгаа ч гэсэн амжаад гарчихна биздээ.

Юу уу?



Гэр яг урд байна...

Юу юугүй гэрлэн дохионы улаан аслаа!



Одоо жаахан хурдалбал гарчихна...



Юу.

Нойтон юм шиг л  
харагдсан даа



Замын гадаргуу  
хөлдсөн байна...

Энэ ослоор би  
хүн гэмтээчихсэн.



Би яах ёстой  
байсан юм болоо...

### Унадаг дугуйгаар явах үед анхаарах зүйл

**Чихэвч зүүж болохгүй!**

Чихэвч зүүвэл ойр орчимд тавих анхаарал сулрах тул осолтой.  
\* Чихэвч зүүж явахыг олон муж хотууд хориглосон байдаг.

**Замын тэмдгийг мөрдөөрэй!**

Түр зогсох тэмдэг байгаа газар заавал түр зогсож байгаарай.


**Шөнө орой, цаг агаар таагүй үед үзэгдэх орчин хязгаарлагдмал болдог!**

Оройн цагаар эсвэл цаг агаарын таагүй үед зайны мэдрэмж болон эд юмсыг харж мэдрэхэд хэцүү болдог тул анхааралтай явцгаая.

**Явган хүний гарцыг бууж явганаар гарцгаая!**

Явган хүний гарцын явган зорчигчийн хэсгийг гарах үед явган зорчигчид саад болохоор бол унадаг дугуйгаа түрж явцгаая.

Ялангуяа цастай, хүйтэн өдрүүдэд мөстсөн замд болгоомжтой байгаарай.



Унадаг дугуй бол гэмт буруутан болгох боломжтой тээврийн хэрэгсэл юм ...!

Хохирогчдыг хамгаалахын тулд ч унадаг дугуйн нөхөн төлбөрийн хариуцлагын даатгалд хамрагдаарай.







## Зам тээврийн үйлдвэрлэлийн ослоос сэргийлэхэд анхааруштай гол санаа




### 1 | Замын хөдөлгөөний дүрмийг баримтал




Замын хөдөлгөөний дүрмийг үл ойшоосон аюултай хөдөлгөөн хийхээ зогсооё.

### 2 | Ачааны машины сохор бүсийг анхаарах



Ачааны машин зэрэг тээврийн хэрэгсэлд сохор бүс байдаг. Зүүн гар тийш эргэхдээ хойт дугуйн мөрний зөрүү ч анхаарах хэрэгтэй.

### 3 | Унадаг дугуйгаар явахдаа дүрмийг баримтал



Ялангуяа доорх дүрмийг дагаж мөрдөөрэй.

- Унадаг дугуйг зарчмын үүднээс, замын зорчих хэсгээр унацгаая (явган хүний замаас бусад).
- Замын зорчих хэсгийн зүүн гар талаар явцгаая.
- Явган замд явган зорчигч давуу эрхтэй бөгөөд замын зорчих хэсэгтэй ойрхон тайван аажуу явцгаая. Явган зорчигчдод аюул осол мэдрүүлэхгүй байхаар явцгаая.


### 4 | Гэмт буруутан болох магадлал байдаг.




Унадаг дугуй, автомашин нь тухайн тохиолдлоос хамааран гэм буруутан болж хувирдаг.




Хохирлыг бууруулахын тулд толгойгоо хамгаалах унадаг дугуйн зориулалтын дуулга өмсөх нь ч чухал шүү.



Үйлдвэрлэлийн осол нь өөрт ойр байдаг асуудал бөгөөд, өөр бусад хүмүүсийн асуудал огт биш юм.




Өөрийн амь нас ч мэдээжийн хэрэг бөгөөд, бусдын амь насанд ч аюул учруулах зүйл тул замын хөдөлгөөний дүрмийн ач холбогдлын талаар сайтар бодож үзэхийг хүсэж байна.



Зөвхөн ажилдаа ирж очих үед бус, ажлын талбар дээр ч аюул осол байгаа гэдгийг анхаарч байхгүй бол болохгүй.



За тэгэхээр!



Маргаашнаас дахин хичээцгээе!

Комикоор мэдэх

## Зам тээврийн үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх нь

2022 оны 3-р сарын хэвлэл

Хэвлүүлсэн: Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яам

Төлөвлөн хэрэгжүүлсэн: Mizuho Research & Technologies, Ltd.

Хамтран ажилласан: Зам тээврийн ослын аюулгүй байдал эрүүл ахуйн боловсрол сургалтын материал боловсруулах ажлын хэсэг

Хэвлэсэн: Sideranch Inc.



Энэ материалтай холбоотой холбоо барих  
Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яамны  
Хөдөлмөрийн стандартын товчооны  
Аюулгүй ажиллагааны хэлтэс,  
Аюулгүй байдал, эрүүл ахуйн газар